



ИЖИЙ СУРГААЛ ТҮҮНИЙ МӨНХ ОРШИХУЙН АМИН ШҮТЭЛЦЭЭ

Ц.Энхээ

МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн багш

Abstract: In this article, I want to share our opinion about Mongolian mother's morality in accordance with mother's lullaby and true love for her children. From ancient times the indication of Mongolian nomadic tradition was connected to the customs of respect for mothers. We believe that Mongolian mothers are – the first teachers for their children. The principle of mother's morality management is commonly aphorism or laconicism using proverbs which help her child become a perfect person. Mother's aphorism and proverbs are the treasure of human society which derived from daily life encounters. Also, it promotes the realization and appreciation of this oral treasure of Mongolia. This article intended to discuss mother's lullaby /nursery rhymes/ which will be essential to educate their children. In learning from their mothers' morality management obtained through their life experiences, young women educate their children which will definitely lead to a full, fruitful, and healthy life.

Түлхүүр үг: бүүвэйн дуу, эхийн хайр, ижий ухаан, эхийн сургаал, ээжийн үлгэрлэл

Оршил

Монгол эхийн сургаал нь Монголчууд олон зууны туршид үр хүүхдээ хүн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн, амьдрахуйн өв тэгш ухааныг агуулсан хамгийн эрхэм үнэт зүйлсийн дээд нь юм.

Эхийн сургаал нь цаг үргэлж давтагдах тул ахуйн, магадгүй бүр энгийн гэж ойлгогдохоор боловч түүний дотоод амин чанар нь ертөнцийн юмс үзэгдлийн учир холбогдол, хүмүүний амьдралыг таньж

ухаарахуйн илэрхийлэл, хэдэн үеэрээ уламжлан үр хүүхдээ зөв хүмүүжүүлэхэд мөрдвөл зохих амин сургаал гэдгээрээ онцлогтой.

Монгол эхийн сургаал сургамжаар бичигдсэн тусгай ном сурах бичиг хэдийгээр олон байдаггүй ч эхийн сургаалийг магтан дуулаагүй нэг ч яруу найрагч зохиолч үгүй. Учир нь угаас нүүдэлчин ахуй заншилтай монголчуудын гэрийн доторх аж амьдралын хэв маяг үр хүүхдийн хүмүүжил зэрэгт тухайн өрхийн эзэгтэйн ёс суртахууны төлөвшил, гэр бүлээ асран халамжлах ухаан, үлгэр дууриал, хувийн зан үйл нь чухал нөлөөтэй байдаг.

1. Ижий сургаалийн утга санаа.

Хүн бол нийгмийн амьтан учраас хөгжлийн аясаар хүмүүсийн ахуй амьдрал, сэтгэл зүйд өөрчлөлт ордог ч биенээс бие, амьнаас амь болж тасарсан үр хүүхэд эхийн халуун хайр, эхийн зөв энергийн орон зайд ойр оршиж эхийн бүлээн сүүгээр торниж, ээжийн бүүвэйн дуу, эхийн сургаалийг хүлээж авдаг тэрхүү рефлекс нь өөрчлөгддөггүйд эхийн сургаалийн амьдлаг чанар оршино.

Монголчууд бичиг үсэг хөгжөөгүй эрт дээр үеэс ардын аман сургаалийг хэлэлцэн гэрийн хүмүүжлээр буюу эхийн сургаалаар үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн нь түүхэнд тэмдэглээстэй. Соёл иргэншлээрээ дэлхийд гайхагддаг байсан Ази төвтэй Дорнын соёл, тэр дундаа монголчуудын уламжлалт соёлыг монгол орноор дайран өнгөрсөн эрдэмтэн судлаачид зохиол бүтээлдээ олонтаа дурдсан байдаг. “Монголчууд чимээгүй үгээр

ярилцан, хөгжил баярын царайгаар эелдэг мэндлэлцэн, нэр төрөө ихэд сахидгаас гадна идээлж будаалах нь нэн ёсорхуу, эцэг эхдээ маш их хүндлэл үзүүлнэ” гэж Марко Поло бичжээ (Орхон, 2006).

Мөн судлаач Плано Карпини: “Монголын эрчүүд нь нум сум хийх бөгөөд хүүхэд үүхэдгүй сайн харваачид ажгуу. Хүүхдийг гурван нас хүрмэгц морь унуулж, хавчаахай нум, нум сумаар харвуулж сургах тул тэд самбаа зориг ихтэй. Охид хүүхнүүд нь ч морь унаж давхихдаа эрчүүдээс дутахгүй. Тэд мөн л эрчүүд шигээ нум сум агссан байхыг бид харсан” гэж монголчуудын өв тэгш хүмүүжлийн тухай тэмдэглэжээ (Орхон, 2006).

Гадныхүний нүдэнд бахархалтай үзэгдэх ийм зөв хүмүүжил, өв тэгш ёс суртахууныг монголчууд хэрхэн төлөвшүүлдэг нь мөнөөх монгол эхийн сургаал сургамж монгол гэр бүлийн хүмүүжлээс эхтэй.

Монголчууд үр хүүхэддээ домог, туульс, үлгэр ярьж өөрсдийн түүх соёлыг аман хэлбэрээр уламжлуулдаг заншилтай ард түмэн юм. Ихэвчлэн цэцэн мэргэн, суу билэгт хатадын сургаал, ишлэл, домгийг ярьж ухааруулан сургадаг нь монгол эхийн сургаал сургамж түүний үзэл санаа утга чанараа хадгалан хэдэн зууныг дамжин монгол айл өрх бүрд мөнх оршиж байдгийг илтгэнэ. Мөн монголчуудын удам угсааны цэдэг /бичиг/ нь гэрийн хүмүүжлийн гол санаануудыг тусгасан гэр бүлийн уламжлал, эв эеийг эрхэмлэх, хүүхдийг хүмүүжүүлж төлөвшүүлэхэд зориулсан монгол сурган хүмүүжүүлэх ухааны нэгэн хэлбэр юм.

Өдөр өдрөөр холдож буй ардын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал, монгол ахуй, нүүдэлчдийн өв соёлыг сөхөн сонирхвол монгол хатадын агуу ухаан түүхийн тэртээгээс дэндүү тод томруун үзэгдэнэ. Хатад эгэл борог амьдралтай харц ардын гэр бүлд төрж өсөөд өөрийн төрсөн жил урвасан мэнгэний учир шалтгаанаар хааны хатанд өргөмжлөгдсөн түүх Монголд элбэг. Үүнээс үзвэл хааны хатанд өргөмжлөгдсөн тэр “их хувь заяат” эмэгтэйг жирийн харц ядуу монгол ээж төрүүлж эрхэм хүн болгон төлөвшүүлсэн нь тодорхой.

Монгол ээжүүд үр хүүхэддээ аливааг тайлбарлан таниулж, тэдний мэлмий ухааныг нээж, өөрийн үйлдэл бүхнээр үлгэрлэн, өөрсдөөр нь үйлдүүлэх, харах, үзэх, сонсох, хүртэхийг зэрэг мэдрүүлдэг байсан нь монгол сурганы уламжлалт хэв маягийн илэрхийлэл юм. Ээжүүдийн сургаалд ээжийн бүүвэйн дуу, монгол ардын зүйр цэцэн үгс зонхилдогийг ажиглаж болно. Эрт дээр үеэс эцэг өвгөд маань үр хүүхдээ хөдсөн нэхий, даалимба даавууханд өлгийдөх атлаа ухаант мэргэдийн сургаал, ном судрыг торго дурданд ороон дээш нь залж эрхэмлэж ирсэн нь ч учиртай.

Өв тэгш хүн болгон хүмүүжүүлэхэд тухайн цаг үе, төр нийгмийн байдал нөлөөлдөг нь тодорхой ч монгол ээжүүд өөрсдийн өмнөх үеийн цэцэн билэг оюун ухаан төгөлдөр монгол хатадын эш үг, эрдэм ухаанаар охидоо хүмүүжүүлэхийг эрхэмлэдэг нь анхаарал татдаг. Монгол ээжүүд үр хүүхдээ хоёр гуравхан холбоо үгсээр сургамжлан төлөвшүүлсээр тэдэнд ухаан ургуулдаг дадал заншилтай. Тэр сургамж үгнээс нь хүүхэд яагаад ч юм бэ нэг санааг өлгөж авахаар утга учиртай уран яруу холбоо үг хэллэгтэй байдаг нь гайхалтай. Жишээ нь: “Уруудахад унтах идэх,,, гэх юмуу “Насны багад эрдэм сурахад залхуугүй бол нэн сайн”, “Энэ бие өсөөд ээжийгээ хялайх нь нүгэл - Эрдэм ном сураад багшийгаа муулах нь нүгэл” гэх зэрэг зүйр цэцэн үгсээр хэлэлцэж сургахад хүүхэд утга санааг нь ойлгож “ер нь унтаж, идэж залхуураад байвал уруудах” бололтой гэдгийг ухаарч, болгоомжлох зэргээр өөрийгөө анхаардаг байна.

Эхийн сургаал сургамжийн гол философи болох монгол ардын цэцэн мэргэн ухааны илрэл зүйр цэцэн үгс нь манай ард түмний амьдралын гүн ухааныг агуулсан, нүүдэлчдийн сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илэрхийлсэн хүнийг аж төрөхүйн зөв чиг хандлагатай болгон төлөвшүүлэхэд маш их тустай билээ. Монгол ээжүүдийн сургаал сургамжийг авч үзвэл хүүхдийн нас насны онцлогт тохирсон сургамжит үг хэллэгийг хэрэглэдэг нь бас ажиглагдана.

Монгол ээжүүдийн хүүхдээ сургаж



хүмүүжүүлдэг арга нь ерөнхийдөө адил төстэй. Түүхийн аль ч үед ээжүүд хүүхдээ сургаж хэлдэг, зэмлэж хэлдэг, урамшуулж хэлдэг, хүүхдийнхээ сайн сайхны төлөө залбирч мөргөдөг зэрэг нь ижил байдаг.

Дээр үед монгол ээжүүд олон хүүхэд төрүүлдэг байсныг статистик судалгаанаас харж болно. Арав түүнээс дээш хүүхэдтэй айлууд ч олон байв.

Тийм тооны хүүхдүүд гэдэг өнөөдөр бол цэцэрлэгийн нэг анги. Тэр цагт ээжүүд арваад хүүхдийг өлсгөхгүй, дааруулахгүй, хайраар дутаалгүй, халуун дулаан эрч энергитэй бүүвэйн дуугаа аялан өсгөж, цэцэн билэгт гүн ухаан, уран яруу үгсээрээ хүмүүжүүлж ирсэнийг бодоход тэд үнэхээр гайхамшигтай сурган хүмүүжүүлэгчид юм. Ямар ч сургууль эрдэмд суралцаагүй атлаа эцэг өвгөдөөс магадгүй өөрийн ээжээс оюун санаагаараа өвлөж үлдсэн - ижий боловсролоор үр хүүхдээ өв тэгш хүн болгож төлөвшүүлдэг нь жинхэнэ монгол ээжийн - ижий хайраас урган гардаг монгол ухаан мөн. Түүнчлэн монгол ээжүүд айлын том хүүхдүүд дүү нараа хүмүүжүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэх ёстойг онцгой анхаарч “ах нь сургаж дүү нь сонсдог” зарчмаар хүүхдээ хүмүүжүүлдэг байсан нь хүмүүний хоорондын харилцааг зөөллөхөд сургах ижий ухааны илрэл билээ.

Энэ мэт олныг ухаан үзвэл хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлдэг нарийн нандин арга ухаан монгол ээжүүдийнх гэвэл зохилтой. Монголчууд бид гадныханаас ихийг сурч судалж болж байгаа юм чинь, үе үеийг дамжиж ирсэн монгол ээжийн сургаал сургамжийг айл бүрийн ижий нар судалж үр хүүхдээ бүүвэйн дуу, эхийн гэгээн сургаалаар дутаалгүй өсгөж улмаар ижий -багш нар хүүхдийг ижий сургаалаар гэгээрүүлэн хүмүүжүүлэх арга барилыг эзэмшин өвлөж яагаад болохгүй гэж ...

Тэгээд ч монгол хүний цэцэн билэгт оюун ухаан, зориг самбаа, тэсвэр тэвчээр, өв тэгш төлөвшлийг бөмбөрцгийн хүмүүс бүлтийн биширдэг нь нууц биш. Монгол ээжийн сургаал сургамжаар өсч төлөвшсөн хөвгүүд эртний түүхэнд тэмдэглэгдсэнээр хамгийг оройлсон - “хаан хөвгүүд”, “хаан

ээд” болдог байсныг эс өгүүлэн өнөө цагт мөн л монгол ээжийн төрүүлж сургаж хүмүүжүүлсэн хөвгүүд хаа тэртээ энхийг сахиулах албанд, сумогийн дэвжээнд, олимп, дэлхийн аваргын тэмцээнүүдэд илүүрхэн гайхуулж, ээжийн туяхан охид гоо үзэсгэлэнгээрээ бишрүүлж, оюунлаг олон залуус гадаад хэлийг төрөлх хэл шигээ эзэмшсэнээр гадны улс гүрэнд өндөр албыг хашиж дэлхийг дэлдийлгэж яваа нь монгол ээжийн сургаал сургамжийн үр дүн биш гэж үү ?

2. “Ижий сургаал сургамж мөнх орших нь.

Нэгэнт ижий сургаал сургамжийн талаар өгүүлж байгаа тул монгол ээж бүхэн “**сурган хүмүүжүүлэгч**” гэж хэлэх гэсэн юм. Ийнхүү ээж багшийн гэрийн хүмүүжлээр төлөвшсөн хүүхэд цэцэрлэг, сургуулийн босго алхан сурагч болж “Багш-ээж”-тэй золгосноор цаашид мөн л ижий сургаалийн орчинд суралцаж байдаг. /Манай улсын боловсролын салбарт, ялангуяа цэцэрлэг, бага сургуулийн багш нарын ихэнх нь эмэгтэйчүүд байдгаас “ижий багш” угтаж авдаг/

Ижий сургаалийг энгийнээр ажвал үр хүүхдээ алхам тутамд нь зааж сургасан, засч залруулж, гэгээрүүлж хайрласан шинжийг агуулдаг .

Ер нь сайн ээжийн өсгөж хүмүүжүүлсэн хүүхэд өөрийн амьдарч буй цаг үеийг эзэлсэн их хаад, эрдэмтэн гүүш болон бусдаас ялгардаг нь түүхээс тодорхойг дээр дурдав.

Монгол ээжүүд үр хүүхэддээ өөрийн сургаал сургамжийг хэзээ, ямар орчин нөхцөлд, ямар арга ухаанаар хэлж ярихаа маш сайн мэддэг, мэдэрдэг зөнч хүмүүс. Өөрөөр хэлбэл монгол ээж бүхэн хүүхэдтэйгээ ажиллах, тэднийг сурган хүмүүжүүлэх өвөрмөц арга барилтай, магадгүй өөрийн гэсэн сурган хүмүүжүүлэх багц хичээлийн хөтөлбөр нь хавтас файлаар бэлтгэгдсэн харагдахгүй ч ээжүүдийн сэтгэлийн дотоодод, цэцэн оюу ухаанд нь эмх цэгцтэйхэн оршиж байдаг .

Тиймээс хэн ижий сургаалийг эрхэмлэн дээдэлж, сургамжлан хэлэх үгний амьдлаг

эрчим мэдэрч үнэ цэнэтэйг ухаарч ойлгоно тэр хүн амьдралын зөв чиг мөрийг олж зөв төлөвших бөгөөд чухам үүнд л ижий сургаалийн мөнх оршихуйн учир шалтгаан нуугдмуй.

Судалгааны үр дүн

Эрт дээр цагаас монгол ээжүүдийн хүүхдээ хүмүүжүүлэх сургалтын хамгийн тохилог орчин нь “монгол гэр” байсан гэдэг нь олон зүйлээс харагддаг. Хаалга, хатавч хаяагаар нь цэвэр агаар салхи нэвт үлээж ухаан саруулсгах өргөө гэрт, тооноор нь наран дүүрч гэрийг бүтэн тойрон дулаан илчээ түгээх, тулганд нь амьд гал дүрэлзэн халуу дүүгэх ийм эрч энергитэй орчинд мэдээж дээр нь ээжийн гарын амтат цай хоолтой давхцуулан ижий сургаал сургамж сонсох нь хүүхдийн хувьд үнэнхүү тааламжтай хүлээж авууштай, бас өндөр үр дүнтэй байх нь тодорхой. Түүхээс уншихад Алунгоо эх “хаврын нэгэн хавсрагатай өдөр хатаасан /хуршсан/ мах чанаж идүүлэх зуур хөвгүүддээ сургаал айлдсан” тухайд өгүүлсэн байдаг билээ.

Үүн лугаа ээжийн хайр халамж, халуун хоол унд нүүр нүүрээ харан ярилцах орчин зэрэг нь сургаж хүмүүжүүлэх үйл явцад маш их эерэг нөлөөтэй болох нь харагдана. Судалгаанаас болон өөрийн сурган хүмүүжүүлэх туршлагаас харахад суралцагчдын төлөвшил байдал ихээхэн ялгаатай нь анзаарагддаг. Бусадтай хүндэтгэлтэй харьцдаг, зөв төлөвшиж яваа хүүхдүүдтэй ярилцахад тэд сургуулийн өмнөх боловсролыг гэрээр буюу эмээгээсээ зарим нь ээжээсээ олж авсан гэж хариулдаг. Энэ нь мөнөөх ижий сургаал сургамжийн нөлөө үр дүн юм

ДҮГНЭЛТ

Монгол эхийн эрхэм сургаал сургамжийг яг тэр хэвээр нь биш юмаа гэхэд өнөөгийн нийгмийн араншинд тохируулан ээж бүхэн үр хүүхдээ хүмүүжүүлэхэд хэрэглэж болмоор санагдана. Өнөө цагт хэвшил болоод байгаа олон өрөө байранд эх хүүхдүүд тус тусдаа амьдардаг хэв маяг мөн ээжүүд өглөө хүүхдэдээ бэлдэж өгдөг хүйтэн ундаа, хүйтэн зууш салат, өдөр юм авч идээрэй гэж

мөнгө өгдөг зэрэг нь хүйтэндүү харьцааг бий болгож мэдэх бөгөөд ээжүүдийн хэлж сургадаг сургамж нь хүчгүүддэг байж ч болох сөрөг талтайг эрх биш бодмоор санагдана.

Ерөнхийдөө орчин үеийн ээжүүд хүүхдээсээ хол хөндий болж байгаа нь ажиглагддаг. Түүгээр зогсохгүй мөнгө төлж гадаад хүнээр нярай хүүхдээ асруулдаг, тэр нь хүүхдийг нь өвөртөлж унтдаг хэмээн бэрдээ гоморхсон нэгэн ээжийн яриа дээрхийг бэлхэнээ нотлоно.. Тэр ээж хүүхдээ хэвлийдээ тээж төрүүлсэн ч харь хүний биед тэврүүлэн өсч буй хүүхэд нь харь хэл соёлоор өсч торниод хэнийг нь “ ижий минь” гэж хайрлах бол гэдгийг бас бодмоор...

Манай дээд үеийн гэгээрсэн хувилгаадын бичиж үлдээснээр бол: “ Цөвүүн цаг ирэхэд монгол ёс уламжлалаа сэргээн түүнийг дагаж мөрдсөнөөр сайн мөрийг олох” тухайд эшлэн өгүүлсэн байдаг.

Монголчууд бидэнд хэнээс ч тусламж хүсэхгүйгээр үр хүүхдээ монгол ухаанаар төлөвшүүлэх оюун санааны асар их баялаг бий. Монгол ээжүүдээс хүүхэд төрж л байгаа цагт монгол эхийн гайхамшигт сургаал сургамж нь мөнх оршино.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Адъяа, Д. (2006). *Монгол ёс заншил ба домнох ёс*. Улаанбаатар
- Гаадамба, Ш. (1990). Сурган хүмүүжүүлэх уламжлал монголын нууц товчоонд тусгагдсан нь. *МНТ-судлалын зарим асуудал*. Улаанбаатар
- Гонгоржав, Г. (1992). *Монголчуудын эрдэм ухааны уламжлал*. Улаанбаатар
- Гэрэлт цалиг сэтгүүл. УБ. 2012 оны № 22
- Жиованни дель Плано Каприни. (1988). Монголчуудын түүх. Улаанбаатар
- Золзаяа, Л., Дашням, Л. (2007). Эртний хатадын эш үгс. Улаанбаатар
- Насанбат, Ш. (2013). *Монголын түүхийн эрт эдүгээх 33 хатад*. Улаанбаатар
- Пүрэвбат, Г. (2009). *Ирээдүйг эш үзүүлсэн бошгууд*. Улаанбаатар